

**Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий орлого,
зарлагын мөнгөн гүйлгээ**

(Шилэн дансны тухай хуулийн 6.4.5 дахь заалтын хүрээнд)

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэр: Эрүүл мэндийн сайд
Төсвийн захирагчийн нэр: Н.Цогбадрах

Дансны дугаар: 100900020021		Дансны нэр: ЗӨСҮТ		төгрөгөөр	
Огноо	Харилцагч байгууллага	Орлого	Зарлага	Гүйлгээний утга	Шийдвэрийн хуулбар
2017.05.09	ДЭМБ	118,502,400		"Хөндлөнгийн хамтарсан үнэлгээ" сэдэвт хурлын санхүүжилт	Удирдамж

Энэхүү тайлантай холбоотой тодруулгыг доорх хаягаар холбогдох авна уу.

Дарга: Н.Цогбадрах, 99030301

Няглан бодогч: З.Ууганцэцэг, 99060109

ЗАХИРАЛ

БАТЛАВ

Н.ЦОГБАДРАХ

**“ХӨНДЛӨНГИЙН ХАМТАРСАН ҮНЭЛГЭЭ” СЭДЭВТ
ХУРЛЫН УДИРДАМЖ**

Үндэслэл:

2005 онд ДЭМБ-ын Номхон Далайн Баруун Эргийн Бүс ба Зүүн Өмнөд Азийн бүсийн байгууллагууд хамтран Ази Номхон Далайн Сэргэж буй Өвчний Стратегийг (APSED) баталсан. Энэ стратегид олон салбарын нягт хамтын ажиллагаатай байх нь халдварт өвчнийг хянах, урьдчилан сэргийлэхэд чухал гэж тодорхойлсон байна.

Монгол улсад ОУЭМД-ийн зохицуулагч байгууллагын үүргийг 2011 оноос хойш Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв гүйцэтгэж улмаар цар хүрээ нь өргөжиж халдварт өвчний дэгдэлтээс гадна гамшиг, хими цацраг, хүнсний аюулгүй байдалтай холбоотой эрсдэлийг багтаах болсон.

ОУЭМД-ийн Удирдах Зөвлөлөөс 2015 оны Дэлхийн Эрүүл Мэндийн Чуулга уулзалтаар “... дан ганц өөрийн үнэлэх аргаас гадна өөрийн үнэлгээг хөндлөнгийн үнэлгээ, газар дээр нь үнэлэх аргуудтай хослуулан салбарууд болон олон улсын төлөөлөл оролцуулан ” хийхийг зөвлөмж болгосны дагуу Олон Улсын Эрүүл Мэндийн Дүрмийн (ОУЭМД) хэрэгжилтийн хамтарсан хөндлөнгийн үнэлгээ хийхийг зөвлөмж болгож байна. Иймд бид тандалт, хариу арга хэмжээ, ОУЭМД-ийн чадавхи, бодлогын бичиг баримт, холбогдох заавар журам, ОУЭМД-ийн хэрэгжилтийн байдлыг үнэлж, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай байна.

Зорилго:

Олон Улсын Эрүүл Мэндийн Дүрмийн (ОУЭМД) хэрэгжилтийн хамтарсан хөндлөнгийн үнэлгээ хийж, үнэлгээний үр дүнгийн уулзалт хурал зохион байгуулж, зөвлөмж боловсруулах.

Зохион байгуулах байгууллага: ЭМСЯ-ны харьяа ЗӨСҮТ, ХӨСҮТ

Сургалтад оролцох байгууллагууд: ЭМЯ, МЭҮГ, ХӨСҮТ, ЗӨСТ, ОБГ, МЭХ, НЭМХ, Сэлэнгэ, Хөвсгөл, Завхан, Дорноговь аймгийн ЭМГ, ОБ-ийн мэргэжилтэн нийт 150 хүн

Зохион байгуулах хугацаа: 2017 оны 05-р сарын 13-наас 19-ны өдрүүд

Санхүүжүүлэгч: ДЭМБ

Үйл ажиллагааны зардал: 118,502,400₮

Гүйцэтгэх үйл ажиллагаа:

1. ДЭМБ-ын ХХҮ аргачлалын дагуу үндэсний мэргэжилтнүүд өөрийн үнэлгээг хийнэ
2. Гадны үнэлгээний баг дотоодын үнэлгээний дүнтэй урьдчилан танилцана
3. Гадны үнэлгээний баг ХХҮ-ний аргачлалыг ашиглан үндэсний мэргэжилтнүүдтэй хамтран чадавхийг үнэлнэ

Гарах үр дүн

Үнэлгээний үр дүнд үндэсний аюулгүй байдлын чухал асуудал, хэрэгцээг тодорхойлогдож, бэлэн байдал, хариу арга хэмжээг сайжруулах ажлын салбар хоорондын төлөвлөгөөнд тусгагдахаас гадна одоогийн болон ирээдүйн түншлэгч байгууллагуудад асуудлыг шийдвэрлэх, хөрөнгө нөөц босгох боломж бүрдүүлнэ.

Боловсруулсан:

ЗӨСҮТ-ийн төсөл хариуцсан мэргэжилтэн *Чемо* Б.Уянга

Хянасан:

МТА-ны дарга



Д.Ганболд